



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/077/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот  
2026 оны 02 дүгээр сарын 25

2026

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584

Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Аудитын менежер:

М.Алтантуяа

Утас: 70442424

Цахим хаяг: [altantuyam@audit.gov.mn](mailto:altantuyam@audit.gov.mn)

Ахлах аудитор:

Б.Нарангэрэл

Утас: 99009293

Цахим хаяг: [narangerelb@audit.gov.mn](mailto:narangerelb@audit.gov.mn)

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.2 Материаллаг байдал .....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.5.1 Завсрын аудитын талаар .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
5.1 Төлбөрийн акт .....	19
5.2 Албан шаардлага .....	20
5.3 Зөвлөмж .....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	22

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ОРОН  
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ З.МӨНХТӨР ТАНАА**

2026.02.24 № 2/38  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн залруулагдаагүй 57,429.5 мянган төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон ерөнхий материаллаг дүнгээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Тайлант хугацааны томилолтын зардлыг тулгахад байгууллагын дарга өөртөө шийдвэр гарган 2 хоногийн томилолт 180.0 мянган төгрөг авсан, мөн мэргэжилтнүүдэд нийт 760.0 мянган төгрөгийн томилолтыг илүү олгосон байна.
- Тайлант хугацааны бараа материалын тайланг тулгахад 10,104.8 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, бичиг хэрэгслийн материал хүнсний материал, тоног төхөөрөмж зэргийг санхүүгийн тайланд орлого болон зарцуулалтыг бүртгээгүй байна.

**6426050116**

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-  
албан тоот.docx

- Тайлант хугацааны нийт зардлыг тулгахад 18,259.1 мянган төгрөгийн 50 гүйлгээг хоорондын тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.1.4 “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 20.2.3 “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1 “Хувьчилсан эд хөрөнгийн үнийг хувьчилж авсан этгээд өөрийн болон хууль ёсоор авсан дотоод, гадаадын зээлийн мөнгөн хөрөнгөөр /үнэт цаасаар/ төлнө” гэсэн заалтууд, мөн УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, УСНББОУС-12 Бараа материал, УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 250,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий виртуал студийг менежментээр хувьчлах гэрээг Айети юнипикэшн ХХК-тай байгуулсан бөгөөд төлбөрийн хуваарийн дагуу 2025 онд төлөх 28,125.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 99.4 хувиар үнэлсэн байна.

Орон нутгийн тээврийн хэрэгсэлд тавих хяналт хангалтгүйгээс орон нутгийн өмчийн зарим байгууллагуудын тээврийн хэрэгсэл сүүлийн 5 жил техникийн үзлэгт хамрагдаагүйгээс хөрөнгө үрэгдэх эрсдэл нийтлэг байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ



**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

**/төгрөгөөр/**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>39,879,891.08</u></b>	<b><u>68,697,992.08</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	42,188.08	28,167,788.08
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	42,188.08	28,167,788.08
3351	Байгууллагаас авах авлага	42,188.08	28,167,788.08
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	39,837,703.00	40,530,204.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	39,837,703.00	40,530,204.00
35410	Бичиг хэргийн материал	402,499.00	285,000.00
35420	Аж ахуйн материал	9,435,204.00	10,245,204.00
35470	Бусад хангамжийн материал	30,000,000.00	30,000,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>10,727,054,851.05</u></b>	<b><u>9,744,942,363.33</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	10,727,054,851.05	9,744,942,363.33
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	10,720,664,551.05	9,738,552,063.33
39201	Барилга, байгууламж, орон сууц	15,737,736,646.21	15,737,736,646.21
39202	Хуримтлагдсан элэгдэл	-5,168,879,598.41	-6,110,391,295.37
39203	Авто-тээврийн хэрэгсэл	856,702,806.06	856,702,806.06
39204	Хуримтлагдсан элэгдэл	-765,457,551.86	-793,265,746.54
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45,684,135.48	24,699,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-29,015,028.84	-15,154,563.28
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,492,033.32	16,571,366.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,124,416.64	-14,050,903.58
39214	Бусад үндсэн хөрөнгө	61,321,341.50	61,321,341.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	-23,114,115.77	-25,934,888.33
39217	Ном	318,300.00	318,300.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	6,390,300.00	6,390,300.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,390,300.00	6,390,300.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>10,766,934,742.13</u></b>	<b><u>9,813,640,355.41</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>3,413,283,072.15</u></b>	<b><u>3,149,211,308.89</u></b>
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	3,413,283,072.15	3,149,211,308.89
<b>421</b>	<b>Урт хугацаат үнэт цаас</b>	3,413,283,072.15	3,149,211,308.89
<b>4211</b>	<b>Төгрөг</b>	3,413,283,072.15	3,149,211,308.89
42111	Бонд	3,413,283,072.15	3,149,211,308.89
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>7,353,651,669.98</u></b>	<b><u>6,664,429,046.52</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	7,353,651,669.98	6,664,429,046.52
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,437,316,335.14	1,748,093,711.68
51210	Өмнөх үеийн үр дүн	2,437,316,335.14	2,701,388,098.40
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-953,294,386.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,916,335,334.84	4,916,335,334.84

**Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>10,766,934,742.13</b>	<b>9,813,640,355.41</b>
----------	--	--------------------------	-------------------------

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>786,756,673.80</b>	<b>736,913,800.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>407,483,457.80</b>	<b>310,712,600.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	407,483,457.80	282,587,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	407,483,457.80	282,587,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	392,653,624.00	282,587,000.00
<b>121</b>	<b>Хөрөнгийн орлого</b>	00.00	28,125,600.00
121002	Өмч хувьчлалын орлого	00.00	28,125,600.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>379,273,216.00</b>	<b>426,201,200.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	18,530,516.00	3,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,530,516.00	3,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	360,742,700.00	423,201,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	360,742,700.00	423,201,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,832,636,975.50</b>	<b>1,686,002,947.41</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,832,636,975.50</b>	<b>1,686,002,947.41</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,418,385,948.98	1,341,688,466.50
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	251,489,417.20	273,629,453.16
210101	Үндсэн цалин	129,034,279.20	136,556,151.00
210102	Нэмэгдэл	98,643,698.00	106,750,436.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,690,000.00	9,260,000.00
210104	Урамшуулал	13,121,440.00	21,062,866.16
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30,233,667.68	33,889,011.93
210201	Тэтгэврийн даатгал	20,169,787.20	22,659,473.86
210202	Тэтгэмжийн даатгал	2,521,300.00	2,750,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,260,600.00	1,594,538.07
210204	Ажилгүйдлийн даатгал	1,260,602.00	1,378,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,021,378.48	5,507,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	300,000.00	500,000.00
210301	Гэрэл, цахилгаан	300,000.00	500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	34,928,500.00	23,717,599.00
210401	Бичиг хэрэг	6,131,000.00	4,859,999.00
210402	Тээвэр, шатахуун	13,000,000.00	10,000,000.00

**Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,498,600.00	4,199,600.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,000,000.00	3,758,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,598,900.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,974,500.00</b>	<b>4,992,500.00</b>
210604	Урсгал засвар	4,974,500.00	4,992,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>17,000,000.00</b>	<b>14,979,600.00</b>
210702	Дотоод албан томилолт	17,000,000.00	14,979,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,579,835.00</b>	<b>7,238,254.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,493,000.00	5,473,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	499,250.00	600,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	399,442.00	422,742.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	200,000.00
210807	Газрын төлбөр	88,143.00	92,512.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,074,880,029.10</b>	<b>982,742,048.41</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,000,000.00	650,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,066,880,029.10	982,091,748.41
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>414,251,026.52</b>	<b>344,314,480.91</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,530,516.00</b>	<b>59,043,900.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	6,238,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	52,805,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,530,516.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>392,653,624.00</b>	<b>282,587,000.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	392,653,624.00	282,587,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>66,886.52</b>	<b>2,683,580.91</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,886.52	2,683,580.91
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>1,045,880,301.70</u></b>	<b><u>-949,089,147.41</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>198,593,557.75</b>	<b>4,205,239.31</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	198,593,557.75	4,205,239.31
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-198,593,557.75</b>	<b>-4,205,239.31</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>-1,244,473,859.45</u></b>	<b><u>-953,294,386.72</u></b>

**Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>771,926,840.00</u></b>	<b><u>708,788,200.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>392,653,624.00</b>	<b>282,587,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	392,653,624.00	282,587,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	392,653,624.00	282,587,000.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	392,653,624.00	282,587,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>379,273,216.00</b>	<b>426,201,200.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	18,530,516.00	3,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрсөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,530,516.00	3,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	360,742,700.00	423,201,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	360,742,700.00	423,201,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>763,926,840.00</u></b>	<b><u>703,793,700.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>763,926,840.00</b>	<b>703,793,700.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>349,675,813.48</b>	<b>359,479,219.09</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	250,128,100.00	273,629,453.16
210101	Үндсэн цалин	129,430,993.00	132,801,647.00
210102	Нэмэгдэл	96,885,667.00	110,504,940.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,690,000.00	9,260,000.00
210104	Урамшуулал	13,121,440.00	21,062,866.16
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	31,494,778.48	33,889,011.93
210201	Тэтгэврийн даатгал	21,430,900.00	22,659,473.86
210202	Тэтгэмжийн даатгал	2,521,300.00	2,750,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,260,600.00	1,594,538.07
210204	Ажилгүйдлийн даатгал	1,260,600.00	1,378,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,021,378.48	5,507,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	300,000.00	500,000.00
210301	Гэрэл, цахилгаан	300,000.00	500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	33,198,600.00	23,600,100.00
210401	Бичиг хэрэг	6,000,000.00	4,742,500.00
210402	Тээвэр, шатахуун	13,000,000.00	10,000,000.00

**Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,498,600.00	4,199,600.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,000,000.00	3,758,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,974,500.00</b>	<b>4,992,500.00</b>
210604	Урсгал засвар	4,974,500.00	4,992,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>17,000,000.00</b>	<b>14,979,600.00</b>
210702	Дотоод албан томилолт	17,000,000.00	14,979,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,579,835.00</b>	<b>7,238,254.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,493,000.00	5,473,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	499,250.00	600,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	399,442.00	422,742.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	200,000.00
210807	Газрын төлбөр	88,143.00	92,512.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8,000,000.00</b>	<b>650,300.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,000,000.00	650,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>414,251,026.52</b>	<b>344,314,480.91</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,530,516.00</b>	<b>59,043,900.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	6,238,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	52,805,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,530,516.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>392,653,624.00</b>	<b>282,587,000.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	392,653,624.00	282,587,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>66,886.52</b>	<b>2,683,580.91</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,886.52	2,683,580.91
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>8,000,000.00</u></b>	<b><u>4,994,500.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>8,000,000.00</b>	<b>4,994,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>8,000,000.00</b>	<b>4,994,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>8,000,000.00</b>	<b>4,994,500.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,000,000.00	4,994,500.00

**Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-8,000,000.00</u></b>	<b><u>-4,994,500.00</u></b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,099,924,090.48	6,330,294,631.64	11,430,218,722.12
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,099,924,090.48	6,330,294,631.64	11,430,218,722.12
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	-218,314,152.12	-218,314,152.12
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,916,335,334.84	2,437,316,335.14	7,353,651,669.98
D01	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,916,335,334.84	2,437,316,335.14	7,353,651,669.98
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	264,071,763.26	264,071,763.26
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,916,335,334.84	2,701,388,098.40	7,617,723,433.24
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	-953,294,386.72	-953,294,386.72
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,916,335,334.84	1,748,093,711.68	6,664,429,046.52

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	424,387,500.00	705,788,200.00	-281,400,700.00	166.3
Татварын бус орлого	424,387,500.00	423,201,200.00	1,186,300.00	99.7
Тусламжийн орлого	424,387,500.00	423,201,200.00	1,186,300.00	99.7
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	424,387,500.00	705,788,200.00	-281,400,700.00	166.3
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	424,387,500.00	423,201,200.00	1,186,300.00	99.7
Орон нутгийн төсвөөс	424,387,500.00	423,201,200.00	1,186,300.00	99.7
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>		282,587,000.00	-282,587,000.00	
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	282,587,000.00	-282,587,000.00	
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	424,387,500.00	420,517,619.09	3,869,880.91	99.1
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	424,387,500.00	420,517,619.09	3,869,880.91	99.1
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	364,703,600.00	361,473,719.09	3,229,880.91	99.1
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	275,760,600.00	273,629,453.16	2,131,146.84	99.2
Үндсэн цалин	140,039,200.00	132,801,647.00	7,237,553.00	94.8
Нэмэгдэл	118,679,600.00	110,504,940.00	8,174,660.00	93.1

**Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Унаа хоолны хөнгөлөлт	11,041,800.00	9,260,000.00	1,781,800.00	83.9
Урамшуулал	6,000,000.00	21,062,866.16	(15,062,866.16)	351.0
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>34,420,000.00</b>	<b>33,889,011.93</b>	<b>530,988.07</b>	<b>98.5</b>
Тэтгэврийн даатгал	23,407,000.00	22,659,473.86	747,526.14	96.8
Тэтгэмжийн даатгал	2,750,000.00	2,750,000.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	1,378,000.00	1,594,538.07	(216,538.07)	115.7
Ажилгүйдлийн даатгал	1,378,000.00	1,378,000.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	5,507,000.00	5,507,000.00	-	100.0
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Гэрэл, цахилгаан	500,000.00	500,000.00	-	100.0
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,100,000.00</b>	<b>23,600,100.00</b>	<b>499,900.00</b>	<b>97.9</b>
Бичиг хэрэг	5,000,000.00	4,742,500.00	257,500.00	94.9
Тээвэр, шатахуун	10,000,000.00	10,000,000.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,200,000.00	4,199,600.00	400.00	100.0
Ном, хэвлэл	300,000.00	300,000.00	-	100.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	600,000.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,000,000.00	3,758,000.00	242,000.00	94.0
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,000,000.00</b>	<b>9,987,000.00</b>	<b>13,000.00</b>	<b>99.9</b>
Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	4,994,500.00	5,500.00	99.9
Урсгал засвар	5,000,000.00	4,992,500.00	7,500.00	99.9
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>15,000,000.00</b>	<b>14,979,600.00</b>	<b>20,400.00</b>	<b>99.9</b>
Дотоод албан томилолт	15,000,000.00	14,979,600.00	20,400.00	99.9
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,272,700.00</b>	<b>4,238,254.00</b>	<b>34,446.00</b>	<b>99.2</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000.00	2,473,000.00	27,000.00	98.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	450,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	600,000.00	600,000.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	422,700.00	422,742.00	(42.00)	100.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	200,000.00	200,000.00	-	100.0
Газрын төлбөр	100,000.00	92,512.00	7,488.00	92.5
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>650300.00</b>	<b>650300.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	650,300.00	650,300.00	-	100.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>59,683,900.00</b>	<b>59,043,900.00</b>	<b>640,000.00</b>	<b>98.9</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>59,683,900.00</b>	<b>59,043,900.00</b>	<b>640,000.00</b>	<b>98.9</b>
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,878,000.00	6,238,000.00	640,000.00	90.7
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,805,900.00	52,805,900.00	-	100.0
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>13</b>	<b>7</b>	<b>6</b>	
Удирдах ажилтан	1	1	-	
Гүйцэтгэх ажилтан	8	4	4	
Үйлчлэх ажилтан	4	2	2	
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>13</b>	<b>7</b>	<b>6</b>	

**Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	5	4	
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4	2	2	

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	3,000,000.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	3,000,000.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	3,000,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,000,000.00
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

**3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газар нь “Орон нутгийн төсөвт байгууллагууд болон Төрийн өмчийн оролцоотой ОНӨҮГ-ын өмч, хөрөнгийн харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хүрээнд зохицуулах мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тогтолцоог олон улсын стандартад хүргэж, бүх шатны төсвийн хөрөнгийн зарцуулалтад хэмнэлт, үр ашиг, ил тод байдал, харилцан тайлагнах болон хариуцлагын зарчмуудыг баталгаажуулж, авилгал гарах нөхцлийг бууруулах, дотоодын үйлдвэрлэгч, гүйцэтгэгчийг дэмжих шударга өрсөлдөөнийг өрнүүлэх нөхцлийг бүрдүүлэх замаар эдийн засгийн хөгжлийг хурдасгахад дэмжлэг үзүүлэхэд оршино” гэсэн зорилгын дор үйл ажиллагаагаа явуулж байна.

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газар нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2025 оны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 953,294.4 мянган төгрөг буюу 8.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өөрчлөлт	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
А	1	2	3	4	5	6
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	39,879.9	0.4%	68,698.0	0.7%	28,818.1	72.3%
Мөнгөн хөрөнгө	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Авлага	42.2	0.0%	28,167.8	0.3%	28,125.6	66667.2%
Урьдчилгаа	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Бараа материал	39,837.7	0.4%	40,530.2	0.4%	692.5	1.7%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,727,054.9	99.6%	9,744,942.4	99.3%	(982,112.5)	-9.2%
Үндсэн хөрөнгө	16,727,095.6	155.4%	16,704,189.8	170.2%	(22,905.8)	-0.1%
Хуримтлагдсан элэгдэл	(6,000,040.7)	-55.7%	(6,959,247.4)	-70.9%	(959,206.7)	16.0%
<b>Нийт хөрөнгө</b>	<b>10,766,934.7</b>	<b>100.0%</b>	<b>9,813,640.4</b>	<b>100.0%</b>	<b>(953,294.4)</b>	<b>-8.9%</b>
Өр төлбөр	3,413,283.1	31.7%	3,149,211.3	32.1%	(264,071.8)	-7.7%
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,353,651.7	68.3%	6,664,429.0	67.9%	(689,222.6)	-9.4%
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>10,766,934.7</b>	<b>100.0%</b>	<b>9,813,640.4</b>	<b>100.0%</b>	<b>(953,294.4)</b>	<b>-8.9%</b>

Эх сурвалж: Байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан

Авлага дансны үлдэгдэл 28,167.8 мянга буюу 28,818.1 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны ажилчидтай холбоотой 42.2 мянган төгрөгийн авлагыг

тайлант онд суутган тооцсон бөгөөд 2025 онд менежментийн гэрээний дагуу 250.0 сая төгрөгийн өртөг бүхий виртуал студийг менежментээр хувьчлах гэрээг Айети юнипикэшн ХХК-тай байгуулсан бөгөөд төлбөрийн хуваарийн дагуу 2025 онд төлөх 28,125.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй тул авлагаар бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 40,530.2 мянган төгрөг болж 692.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 13,732.5 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, нийт 13,040.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан нь бараа материалын данс өсөхөд голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 16,704,189.8 мянган төгрөг болж 22,905.8 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 4,184.5 мянган төгрөгийн өртөг бүхий тавилга эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авч, байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 34 нэр төрлийн 27,090.3 мянган өртөг бүхий хөрөнгийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 7/42 дугаар тогтоолоор актлах шийдвэр гарсны дагуу данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 3,149,211.3 мянга болж 264071.8 мянган төгрөгөөр буурсан нь тус байгууллагын дансанд бүртгэлтэй Азийн хөгжлийн банкны Мон-2301 төслийн зээлийн эргэн төлөлтийг 264,071.8 мянган төгрөгөөр бууруулан бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,664,429.0 мянган төгрөг болж 689,222.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 953,294.4 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Тайлант онд тус байгууллага нь Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ны 450.0 мянган төгрөгийн өртөг бүхий Acolous accounting system 4.0 санхүүгийн программ хангамжийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд тайлант онд лицензийн төлбөр төлөөгүй байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 344,289.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 344,289.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 80,098.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 424,387.5 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

**Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Тайлант онд орон нутгийн төсвийн санхүүжилтээр 424,387.5 мянган төсөв баталсан бөгөөд гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 423,201.2 мянга, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоор 282,587.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 420,517.6 мянган төгрөгийг зарцуулж, төсөвт 2,683.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 420,517.6 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 2,131.1 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 531.0 мянга, хангамж бараа материалын зардал 499.9 мянга, урсгал засвар эд хогшлын зардал 13.0 мянга, томилолт зочны зардал 20.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 34.4 мянга, Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал 640.0 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл / төгрөг/*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт %
1	70426 Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	424,387,500.00	420,517,619.09	3,869,880.91	99.09
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	364,703,600.00	361,473,719.09	3,229,880.91	99.11
2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	59,683,900.00	59,043,900.00	640,000.00	98.93

*Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үр дүнг нэгтгэв.

1. Бүтэц орон тоог Баянхонгор аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн захирамжаар 13 орон тоотой байхаар баталсан бөгөөд Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 04 дүгээр албан даалгаврыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 8/45 дугаар тогтоолоор тус байгууллагын батлагдсан төсвөөс 29,207.8 мянган төгрөгийн санхүүжилтийг буцаан татсанаар цалингийн сан хүрэлцэхгүй болж гүйцэтгэлээр 7 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үйлчилгээний 2 ажилтан цомхотгосон байна.

2. Тус байгууллагын төсөвт хоолны зардлыг 11,041.8 мянган төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр 9,260.0 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд Засгийн газрын Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8.4 дэх заалтыг үндэслэн өдрийн 5.0 мянган төгрөгөөр тооцон олгосон байна.

3. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтран төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим системийг нэвтрүүлэх онол, дадлага хосолсон сургалтыг зохион байгуулахаар нийт 545.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### **3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд тус байгууллагад төсөл хөтөлбөр хэрэгжээгүй болно.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд засаг даргын нөөц хөрөнгөөс хуваарилсан 3000.0 мянган төгрөгийн орлого төвлөрснийг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага нь худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 11 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2025 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг М.Мөнхбат зурж байсан бол 2025 оны 09 сарын 26-аас эхлэн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр З.Мөнхтөр томилогдон, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Л.Дуламсүрэн нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

## **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан нийт төсөвт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөвт зардал 428,452.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,284.5 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 2,784.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2025 оны бичиг хэргийн зардлаас 257.5 мянга төгрөгийн хэмнэлт бий болгосон байна.

## **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2025 онд 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 166 мэдээллийг бүрэн байршуулсан бөгөөд 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

## **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно аудит хийгээгүй.

### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэсэн бөгөөд аудитаар зөрчил илрээгүй байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

байхгүй

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,700.0 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Тайлант хугацааны нярвын шатахууны тайлан санхүүгийн тайлангаас 3,700.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байгаа нь УСНББОУС-1 Топилуулга ба тодруулга, УСНББОУС-12 Бараа материал, мөн иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 69,139.7 мянган төгрөгийн 9 зөрчил<sup>2</sup> илэрснээс 29,904.6 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 13,593.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 25,641.6 мянган төгрөгийн 4 заалт бүхий зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 63,424.8 мянган төгрөгөөр их тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

#### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Тайлант хугацааны томилолтын зардлыг тулгахад байгууллагын дарга өөртөө шийдвэр гарган 2 хоногийн томилолт 180.0 мянган төгрөг авсан, мөн мэргэжилтнүүдэд нийт 760.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2.4-д “Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно.” гэсэн заалтыг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль, тогтоомжийг зөрчиж илүү олгосон томилолтыг зардлыг холбогдох буруутай албан тушаалтнуудаар буцаан төлүүлэх төлбөрийн актыг тогтоож, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1.2 Аймгийн засаг даргын 2025.12.30-ны өдрийн Б/93 дугаар захирамжаар байгууллагын даргад үндсэн цалингийн 40 хувиар үр дүнгийн олгохоор заасан байхад байгууллагын дарга 2025.12.10-ны өдрийн А/18 дугаар тушаалаар өөртөө шийдвэр гарган 3,4 дүгээр улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал болох 839.4 мянган төгрөгийг авсан байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль зөрчиж гаргасан шийдвэрийн дагуу олгосон 839.4 мянган төгрөгийг төсвийн захирагчаар буцаан төлүүлэх төлбөрийн актыг тогтоож, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5.1.3 Тайлант хугацааны менежментийн гэрээний дагуу төвлөрүүлэх орлогыг тулгахад Баянхонгор сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 250.0 сая төгрөгийн өртөг бүхий виртуал студийг менежментээр хувьчлах гэрээг Айети юнипикэшн ХХК-тай байгуулсан бөгөөд төлбөрийн хуваарийн дагуу 2025 онд төлөх 28,125.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 “Дараах үндэслэлийн аль нэг нь байвал хувьчлалыг хууль бус гэж үзэж хүчингүй болгоно”, 63 дугаар зүйлийн 63.1 “Хувьчилсан эд хөрөнгийн үнийг хувьчилж авсан этгээд өөрийн болон хууль ёсоор авсан дотоод, гадаадын зээлийн мөнгөн хөрөнгөөр / үнэт цаасаар/ төлнө” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн хуваарийн дагуу төлөөгүй 28,125.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн актыг тогтоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

## 5.2 Албан шаардлага

5.2.1 Тайлант хугацааны бараа материалын тайланг тулгахад 10,104.8 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, бичиг хэрэгслийн материал хүнсний материал, тоног төхөөрөмж зэргийг санхүүгийн тайланд орлого болон зарцуулалтыг бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5 “бүх орлого”, 14.4.6 “бүх зардал” 20 дугаар зүйлийн 20.2.3 “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2024 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 8.21 “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн байнгын системийг ашиглан бараа материалыг бүртгэнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын орлого, зарлагын бүртгэлийг анхан шатны баримтад үндэслэн тухай бүр хийж, дотоод хяналтыг сайжруулж, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5.2.2 Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн зардлаас сар бүр кофе, цайны зардалд 2978.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардлаас 510.3 мянган төгрөгийг хоол цайны зардалд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид төсвийг зориулалт бусаар зарцуулдаг байдлыг таслан зогсоож зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Зардлын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Байгууллагын даргын 2025 оны А/01 тушаалаар нярав, бичиг хэргийн ажилтныг 1 орон тоогоор баталсан байхад байгууллагын бичиг хэргийн ажилтанд няравын ажил үүргийг хавсаргаж цалингийн 40 хувиар цалинжуулсан байна.

Энэ нь Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид хэрэгцээ шаардлагаа тодорхойлон зайлшгүй хэрэгцээтэй бичиг хэргийн орон тоог эрх бүхий байгууллагын шийдвэрээр батлуулж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

#### **2. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тайлант хугацааны нийт зардлыг тулгахад 18,259.1 мянган төгрөгийн 50 гүйлгээг хоорондын тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;”, Сангийн сайдын 2024 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 3.2 “Зардлын онцлогийг харгалзан холбогдох УСНББОУС-ын шаардлагын дагуу зардлыг бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид зөрчлийг таслан зогсоож, хууль тогтоомжийг мөрдөж, санхүүгийн тайланг УСНББОУС-ын дагуу бэлтгэж байх зөвлөмжийг хүргүүлэв.

### 3. Орлогын данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Тайлант хугацааны дуудлага худалдааны орлогыг тулгахад 1,430.0 мянган төгрөгийн дэнчингийн төлбөрийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.4 “Аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр”, 14.4.5 “.Бүх орлого”, 14.4.6 “Бүх зардал”, 20 дугаар зүйлийн 20.2.3 “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Цаашид нягтлан бодогч дэнчингийн төлбөрийг бэлнээр авч байгууллагын дансанд төлдөг байдлыг таслан зогсоож, орлого зарлагыг тухай бүрд нь нягтлан бодох бүртгэлд заавал тусгаж байх зөвлөмжийг хүргүүлэв.

### 4. Орлогын данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу уралдаант шалгаруулалт зохион байгуулан менежментээр хувьчилж байгаа 2,667,300.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 хөрөнгийн гэрээг нотариатаар баталгаажуулаагүйн улмаас зарим гэрээний хэрэгжилт хангагдахгүй, төлбөрийн хуваарийн дагуу төлөгдөхгүй байх эрсдэл үүсэж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 “Дараах үндэслэлийн аль нэг нь байвал хувьчлалыг хууль бус гэж үзэж хүчингүй болгоно”, 63 дугаар зүйлийн 63.1 “Хувьчилсан эд хөрөнгийн үнийг хувьчилж авсан этгээд өөрийн болон хууль ёсоор авсан дотоод, гадаадын зээлийн мөнгөн хөрөнгөөр / үнэт цаасаар/ төлнө” гэсэн заалтыг зөрчиж байна.

**Өгсөн зөвлөмж:** Цаашид дээрх 3 аж ахуйн нэгжтэй байгуулсан менежментээр хувьчлах гэрээг нотариатаар гэрчлүүлэн шинэчилж, гэрээнд нотариатын мэдэгдэх хуудсаар болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх нөхцөлийг тодорхой тусгах замаар зээлийн эргэн төлөлтийг хангах, эрсдэлийг бууруулах зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруула агуй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацааны нярвын шатахууны тайлан санхүүгийн тайлангаас 3,700.0 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.	1	3,700.0			1	3,700.0	1	3,700.0		
Дүн	1	3,700.0			1	3,700.0	1	3,700.0		

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацааны томилолтын зардлыг тулгахад байгууллагын дарга өөртөө шийдвэр гарган 2 хоногийн томилолт 180.0 мянган төгрөг олгосон, мөн мэргэжилтнүүдэд нийт 760.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг илүү олгосон байна.	1	940.0	1	940.0						
Аймгийн засаг даргын 2025.12.30-ны өдрийн Б/93 дугаар захирамжаар байгууллагын даргад үндсэн цалингийн 40 хувиар үр дүнгийн олгохоор заасан байхад байгууллагын дарга 2025.12.10-ны өдрийн А/18 дугаар тушаалаар өөртөө шийдвэр гарган 3,4 дүгээр улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал болох 839.4 мянган төгрөгийг авсан байна.	1	839.4	1	839.4						
Тайлант хугацааны менежментийн гэрээний дагуу төвлөрүүлэх орлогыг тулгахад Баянхонгор сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 250.0 сая төгрөгийн өртөг бүхий виртуал студийг менежментээр хувьчлах гэрээг Айети юнипикэшн ХХК-тай байгуулсан бөгөөд төлбөрийн хуваарийн дагуу 2025 онд төлөх 28,125.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.	1	28,125.6	1	28,125.6						
Тайлант хугацааны бараа материалын тайланг тулгахад 10,104.8 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, бичиг хэрэгслийн материал хүнсний материал, тоног төхөөрөмж зэргийг санхүүгийн тайланд орлого болон зарцуулалтыг бүртгээгүй байна.	1	10,104.8			1	10,104.8				
Байгууллагын даргын 2025 оны А/01 тушаалаар нярав, бичиг хэргийн ажилтныг 1 орон тоогоор баталсан байхад байгууллагын бичиг хэргийн ажилтанд няравын ажил үүргийг хавсаргаж цалингийн 40 хувиар цалинжуулсан байна.	1	5,952.5					1	5,952.5		
Тайлант хугацааны нийт зардлыг тулгахад 18,259.1 мянган төгрөгийн 50 гүйлгээг хоорондын тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн байна.	1	18,259.1					1	18,259.1		
Тайлант хугацааны дуудлага худалдааны орлогыг тулгахад 1,430.0 мянган төгрөгийн дэнчингийн төлбөрийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.	1	1,430.0					1	1,430.0		

**Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу уралдаант шалгаруулалт зохион байгуулан менежментээр хувьчилж байгаа 2,667,300.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 хөрөнгийн гэрээг нотариатаар баталгаажуулаагүйн улмаас зарим гэрээний хэрэгжилт хангагдахгүй, төлбөрийн хуваарийн дагуу төлөгдөхгүй байх эрсдэл үүсэж байна.	1	0					1	0		
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>65,651.4</b>	<b>3</b>	<b>29,905.0</b>	<b>1</b>	<b>10,104.8</b>	<b>4</b>	<b>25,641.6</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/						
			Төлбөрийн акт		Үүнээс Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>									
<b>Дүн</b>									
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>									
Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн зардлаас сар бүр кофе, цайны зардалд 2978.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардлаас 510.3 мянган төгрөгийг хоол цайны зардалд зарцуулсан байна.	1	3,488.3			1	3,488.3			
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>3,488.3</b>			<b>1</b>	<b>3,488.3</b>			

-----oOo-----



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 19/10560247/БТН-2026/077/НА-ОГА-  
Номгон  
ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацааны менежментийн гэрээний дагуу төвлөрүүлэх орлогыг тулган шалгахад Айти юнипикэшн ХХК гэрээний дагуу 2025 онд төлөх 28,125,600 /Хорин найман сая нэг зуун хорин таван мянга зургаан зуун/ төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 "Дараахь үндэслэлийн аль нэг нь байвал хувьчиллыг хууль бус гэж үзэж хүчингүй болгоно", 63 дугаар зүйлийн 63.1 "Хувьчилсан эд хөрөнгийн үнийг хувьчилж авсан этгээд өөрийн болон хууль ёсоор авсан дотоод, гадаадын зээлийн мөнгөн хөрөнгөөр / үнэт цаасаар/ төлнө", 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн Орон нутгийн өмчийн газрын даргатай байгуулсан "Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй виртуал студийг менежментээр хувьчлах" гэрээний 2.2-д "Айти Юнипикэшн ХХК нь Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Виртуал студын барилгыг хувьчлах үнэ 250,000,000 /Хоёр зуун тавин сая/ төгрөгөөс дэнчинд төлсөн 25,000,000 /Хорин таван сая/ төгрөгийг төлснийг хасч үлдэгдэл 225,000,000 /Хоёр зуун хорин таван сая/ төгрөгийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу гэрээний хугацаа дуусах өдөр хүртэл Орон нутгийн өмчийн газрын 100000510061 дансанд төвлөрүүлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах,

хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төлбөрийг хуваарийн дагуу төлөөгүй 28,125,600 /Хорин найман сая нэг зуун хорин таван мянга зургаан зуун/ төгрөгийг төлбөрийг Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 100000510061 тоот дансанд төвлөрүүлэх.


2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2026 оны 10 дугаар сарын 05-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Мөнхтөр, нягтлан бодогч Л.Дуламсүрэн нарт хариуцуулав<sup>1</sup>.

### ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН<sup>2</sup>:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР

Б.НАРАНГЭРЭЛ



<sup>1</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

<sup>2</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 20/АДСБ0241/БТИА-2026/077/НА-БТН-Номгон  
ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацааны томилолтын зардлыг тулгахад байгууллагын дарга өөртөө шийдвэр гарган 2 хоногийн томилолт 180,000 /Нэг зуун наян мянган/ төгрөг, мөн мэргэжилтнүүдэд нийт 760,000 /Долоон зуун жаран мянган/ төгрөг нийт 940,000 /Есөн зуун дөчин мянган/ төгрөгийн томилолтын зардлыг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2.4-д “Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын

Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хууль, тогтоомжийг зөрчиж олгосон 940,000 /Есөн зуун дөчин мянган/ төгрөгийн томилолтыг зардлыг холбогдох албан тушаалтнуудаар буцаан төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2026 оны 05 дугаар сарын 10-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Мөнхтөр, нягтлан бодогч Л.Дуламсүрэн нарт хариуцуулав<sup>1</sup>.

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН<sup>2</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР

Б.НАРАНГЭРЭЛ



<sup>1</sup> Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

<sup>2</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 21/АД56.0241/БНА-2026/077/НА-СТА-  
ТМЗ Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар 30-ны өдрийн Б/93 дугаар захирамжаар байгууллагын даргад үндсэн цалингийн 40 хувиар үр дүнгийн урамшуулал олгохоор заасан байхад байгууллагын дарга 2025 оны 12 дугаар 10-ны өдрийн А/18 дугаар тушаалаар өөртөө шийдвэр гарган 3,4 дүгээр улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал болох 839,400 /Найман зуун гучин есөн мянга дөрвөн зуун/ төгрөгийг авсан байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь “Төрийн

аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хууль зөрчиж гаргасан шийдвэрийн дагуу олгосон 839,400 /Найман зуун гучин есөн мянга дөрвөн зуун/ төгрөгийг төсвийн захирагчаар буцаан төлүүлэх төлбөрийн актыг тогтоож, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2026 оны 05 дугаар сарын 10-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Мөнхтөр, нягтлан бодогч Л.Дуламсүрэн нарт хариуцуулав<sup>1</sup>.

### ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН<sup>2</sup>:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР **Б.МӨНХБАТ**

АХЛАХ АУДИТОР

**Б.НАРАНГЭРЭЛ**



<sup>1</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>2</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 69/АДСБ 024.1/БМА-2026/077/11А- Номгон  
СА-ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацааны бараа материалын тайланг тулгахад 10,104,800 /Арван сая нэг зуун дөрвөн мянга найман зуун/ төгрөгийн сэлбэг хэрэгсэл, бичиг хэрэгслийн материал хүнсний материал, тоног төхөөрөмж зэргийг санхүүгийн тайланд орлого болон зарцуулалтыг бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5 “бүх орлого”, 14.4.6 “бүх зардал” 20 дугаар зүйлийн 20.2.3 “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2024 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 8.21 “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн байнгын системийг ашиглан бараа материалыг бүртгэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**


6426090214

/documents/2026 он/1. бичиг  
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

1. Бараа материалын орлого, зарлагын бүртгэлийг анхан шатны баримтад үндэслэн тухай бүр хийж, дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилган, биелэлтийг нотлох баримтын хамт 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Мөнхтөр, нягтлан бодогч Л.Дуламсүрэн нарт даалгав<sup>2</sup>.

### АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>3</sup>:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

Б.НАРАНГЭРЭЛ



<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 68/АДСБ 0241/БНА-2026/077/НА-СГА-  
ТМЗ Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн зардлаас 2,978,000 /Хоёр сая есөн зуун далан найман мянган/ төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 510,300 /Таван зуун арван мянга гурван зуун/ төгрөгийг сар бүр кофе, цай, хоолны зардалд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д "Зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийг зориулалт бусаар зарцуулдаг байдлыг таслан зогсоож 2026 онд зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг нотлох баримтын хамт 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

6426090216

/documents/2026 он/1. бичиг  
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Мөнхтөр, нягтлан бодогч Л.Дуламсүрэн нарт даалгав<sup>1,2</sup>.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>3</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: **Б.МӨНХБАТ**

АХЛАХ АУДИТОР:

**Б.НАРАНГЭРЭЛ**



<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно